



<https://publications.dainst.org>

iDAI.publications

DIGITALE PUBLIKATIONEN DES
DEUTSCHEN ARCHÄOLOGISCHEN INSTITUTS

Das ist eine digitale Ausgabe von / This is a digital edition of

Dähne, Burkart

Karabalgasun – Stadt der Nomaden: die archäologischen Ausgrabungen in der frühuigurischen Hauptstadt 2009–2011

der Reihe / of the series

Forschungen zur Archäologie außereuropäischer Kulturen; Bd. 14

DOI: <https://doi.org/10.34780/31bg-9k6m>

Herausgebende Institution / Publisher:
Deutsches Archäologisches Institut

Copyright (Digital Edition) © 2022 Deutsches Archäologisches Institut
Deutsches Archäologisches Institut, Zentrale, Podbielskiallee 69–71, 14195 Berlin, Tel: +49 30 187711-0
Email: info@dainst.de | Web: <https://www.dainst.org>

Nutzungsbedingungen: Mit dem Herunterladen erkennen Sie die Nutzungsbedingungen (<https://publications.dainst.org/terms-of-use>) von iDAI.publications an. Sofern in dem Dokument nichts anderes ausdrücklich vermerkt ist, gelten folgende Nutzungsbedingungen: Die Nutzung der Inhalte ist ausschließlich privaten Nutzerinnen / Nutzern für den eigenen wissenschaftlichen und sonstigen privaten Gebrauch gestattet. Sämtliche Texte, Bilder und sonstige Inhalte in diesem Dokument unterliegen dem Schutz des Urheberrechts gemäß dem Urheberrechtsgesetz der Bundesrepublik Deutschland. Die Inhalte können von Ihnen nur dann genutzt und vervielfältigt werden, wenn Ihnen dies im Einzelfall durch den Rechteinhaber oder die Schrankenregelungen des Urheberrechts gestattet ist. Jede Art der Nutzung zu gewerblichen Zwecken ist untersagt. Zu den Möglichkeiten einer Lizenzierung von Nutzungsrechten wenden Sie sich bitte direkt an die verantwortlichen Herausgeberinnen/Herausgeber der entsprechenden Publikationsorgane oder an die Online-Redaktion des Deutschen Archäologischen Instituts (info@dainst.de). Etwaige davon abweichende Lizenzbedingungen sind im Abbildungsnachweis vermerkt.

Terms of use: By downloading you accept the terms of use (<https://publications.dainst.org/terms-of-use>) of iDAI.publications. Unless otherwise stated in the document, the following terms of use are applicable: All materials including texts, articles, images and other content contained in this document are subject to the German copyright. The contents are for personal use only and may only be reproduced or made accessible to third parties if you have gained permission from the copyright owner. Any form of commercial use is expressly prohibited. When seeking the granting of licenses of use or permission to reproduce any kind of material please contact the responsible editors of the publications or contact the Deutsches Archäologisches Institut (info@dainst.de). Any deviating terms of use are indicated in the credits.

Уйгурын эртний нийслэл Хар балгасанд 2009–2011 онд явуулсан археологийн малтлага судалгаа – Товч агуулга

Орчуулсан *Уламбаярын Эрдэнэбат*

Толилуулан буй нэгэн сэдэвт бүтээлд Монгол Улсын нутаг дахь Уйгурын нийслэл Хар балгаст 2009–2011 онд Монгол-Германы Орхон шинжилгээний ангийн (MONDOгEx) явуулсан малтлагын ажлыг нэгтгэн дүгнэсэн болно. Зохиолын эхэнд Хар балгасын түүхэн тойм ба түүнийг судлан шинжилж ирсэн байдлыг танилцуулав. Дараагийн бүлэгт малтлага судалгааны үр дүн, ялангуяа барилгын археологи, хотын түүхийн хувьд чухал ач холбогдолтой баримтуудыг тодорхойлон гаргаж үнэлж дүгнэхийг оролдов. Эцэст нь малтлагын үр дүнг Монгол, Өмнөд Сибир, Буриадыг хамруулан Төв Азийн эртний хот суурины түүхийн харилцан уялдаа холбоо бүхий нөхцөл байдалд хамааруулан авч үзлээ. Энэхүү нэгэн сэдэвт зохиолыг, анхдагч эх сурвалжуудаасаа болоод олон нийтэд танил бус шахам хэвээр байгаа Уйгурын анхны хаант улсын нийслэл хотын тухай сэдвээр гарсан анхны суурь бүтээл хэмээн ойлгож болно. Хар балгасын судалгааны түүхийг үргэлжлүүлэх явцад, шинээр явуулж буй төдийгүй урьд өмнөх хуучин шинжилгээний материалуудыг харьцуулж байж ерөнхий дүр зургийг гарган ойлголт авахын зэрэгцээ газрын зургийн шинэ сэргэг эх хэрэглэгдэхүүнүүдийг буй болгох бололцоо олдсон юм. Үргэлжлэн хийгдсээр буй эртний судлалын малтлагуудыг үнэлж дүгнэснээр Уйгурын нийслэл хотын түүхийн тухай шинжлэх ухааны анхны нийтлэл ийнхүү гарч байгаа нь Төв Азийн дундад зууны хожуу үеийн нүүдэлчдийн соёлууд дахь хот суурины судалгааны нэгэн бүрдэл хэсэг болох буй за.

Хар балгас нь Төв Азийн хожуу нүүдэлчдийн хот суурины түүхэнд онцгой байр суурь эзэлдэг. Энд морьтон нүүдэлчдийн овог аймгуудыг нэгтгэсэн улс гүрнийг байгуулахын тулд нийслэл хот байх зайлшгүй шаардлагатай гэдгийг анх удаа зарлан тунхагласан билээ. Түүний зэрэгцээ энэ нутаг оронд дан ганц нүүдэллэн малжих амьдралын хэвшлээс тодорхой хэмжээгээр суурьшин аж төрөх соёлын хувирал өөрчлөлт явагдсан юм. Үүнд олон хүчин зүйлс нөлөөлсөн бөгөөд энэхүү хотжих үйл явц хожуу нүүдэлчдийн хувьд анх удаа уйгуруудын дунд үзэгдсэн байна. Нангиад, түрэг судлалын хүрээнд танил болсон уйгурууд хятад, согдуудтай харилцаж байсан хэмээх тайлбар бол энэхүү онцгой үзэгдлийн зөвхөн нэг тал болно. 2007 онд Уйгурын нийслэл Хар балгаст эхлүүлсэн шинжлэх ухааны судалгаа нь өөрийн анхны үе шатнаасаа л энэхүү үйл явцыг илүү сайн ойлгоход онцгой хувь нэмрээ оруулж, дараа дараагийн судалгаа шинжилгээний ажлын үндэс суурь болсон билээ.

Эх сурвалжууд

Ордубалык буюу Хар балгасын тухай бичгийн түүхийн цөөн хэдэн сурвалж мэдэгдэж буйг хятадын түүхийн бичиг зохиолууд, эртний түрэг, уйгурын чулуун хөшөөний бичээс, араб эсвэл перс жуулчны аян замын тэмдэглэл гэж ерөнхийд нь ангилж болно. Хамгийн

чухал бөгөөд Уйгурын нийслэл хоттой шууд холбогдох эх сурвалж бол Хар балгасын гурван хэлээрх бичээс хэмээн алдаршсан дурсгал юм. Давхар хэрэмтэй нэгэн цогцолборын төвд босгосон энэ чулуун хөшөөнд Ай Тэнгридэ (808–821) хаан хийгээд түүний дээдсийн цэргийн алдар гавьяа, уйгурууд манихейн шашныг хүлээн авсан түүхт явдлыг алдаршуулан эртний түрэг, согд, хятад хэл бичгээр сийлэн үлдээсэн байдаг. Ганц энэ хөшөөний бичгээс л гэхэд Уйгурын анхны хаант улсын түүхийн олон үйл явдлыг тодруулан мэдэж авсан бөгөөд манихейн шашин чухал үүрэгтэй байжээ. Хар балгасын шинэ үеийн судалгааны түүх нь эхэндээ одоо бидний мэдэж буйгаар, эндээс урагш 35 орчим км зайтай орших, эртний Монголын нийслэл Хархорумыг сонирхох явдалтай нягт холбоотой байсан аж. Монголын тал нутаг дахь хэмжүүрээр авч үзвэл, Хархорумаас Ордубалык хүртэл тийм ч хол зайтай бус тул багагүй хугацаанд эртний Монголын нийслэл гэж ойлгогдож явсан удаатай.

1891 онд түрэг судлаач эрдэмтэн Вильхельм Радловын удирдлагаар Хар балгасанд ирсэн шинжилгээний анги тус хотыг шинжлэх ухааны үүднээс анх тэргүүнд анхаарч үзсэн байна. Анхны малтлагыг 1912 онд Орос-Польшийн экспедици, Котвич, Масков нар хийсэн бөгөөд тэдний малтлагын зарим баримт бичиг саяхан Польшийн нэгэн архиваас олдсон билээ. Оросын археологич Сергей Киселев 1948–1949 онд Хархорумд өргөн цар хүрээтэй малтлагын ажил гүйцэтгэв. Эртний Монголын нийслэлийг судлахын хажуугаар 1949 онд тэрбээр Хар балгасанд хэд хэдэн газар сорилтын малтлага хийжээ. Харамсалтай нь, эдгээр малтлагын үр дүнг Хархорумынх шиг өргөн хэмжээгээр нийтлээгүй юм. 1949 оноос хойш Хар балгасанд шинжлэх ухааны малтлага судалгаа хийгдсэнгүй. 1976, 1979 онуудад Худяков, Цэвээндорж нар хотын дэвсгэрт гүймэг хайгуул хийж Уйгурын керамкийн тухай судалгаа явуулж байлаа.

Хотын байгууламж

Монгол-Германы Орхон шинжилгээний анги нь малтлага судалгаа хийхийн өмнө 2007 онд хотын дэвсгэрийг Airborne Laserscan аргаар зураглаж, 19 дүгээр зууны сүүлчээр Радловын экспедицийнхний үйлдсэн, тэр болтол цорын ганц гэгдэж байсан дэвсгэр зургийг сольсон юм. Хэмжилт судалгаагаар хотын барилга байгууламж бүхий талбайн хэмжээ 32 км² орчим болохыг шинэчлэн тогтоожээ.

Хотын дэвсгэр зургийг ажиглахад барилгуудын чиглэл нь эртний түрэг, уйгуруудад хэвшмэл байсан дорно зүгийг эрхэмлэдэг заншлаас нэг их зөрөх юмгүй аж. Хотын хамгийн өвөрмөц хэсэг нь Ордон, эсвэл Сү-

мийн хот хэмээгдэх дүүрэг бөгөөд бүр 19 дүгээр зууны сүүлчээс судалгааны аялал хийгсдийн анхаарал сонирхлыг татсаар иржээ. Тал нутгийн дунд алсаас сүндэрлэн харагдах бараг 8 м хүртэл өндөр хадгалагдсан хэрмийг нь Төв Азийн бүс нутагт түгээмэл хэрэглэж асан hangtu хэмээх арга маягаар барьсан ажээ. Хотын хэрмээр хүрээлүүлсэн энэхүү хэсэг бол Хар балгасын тахил шүтээн, засаг захиргааны төв байсан хэмээн тооцогддог. Үүрэг зориулалтыг нь бүрэн дүүрэн тодорхойлоогүй байгаа тул Ордон, эсвэл Сүмийн гэж нэрлэж байгаа энэ дүүргийг төслийн хээрийн шинжилгээний хүрээнд НВ 2 гэж тэмдэглэсэн юм. Түүний ерөнхий дэвсгэр зураг нь Төв Азийн бүс нутгийн эртний түрэг, уйгурын үеийнх гэж үздэг олон хэрэм байгууламжтай адилсах боловч харин тэдгээр байгууламжууд нь ямагт ганц ганцаар, эргэн тойронд нь суурьшлын өөр зохион байгуулалт байдаггүй билээ. Хотын доторхи Ордон, эсвэл сүмийн хэмээж буй дүүргийн байршил нь шууд харахад л онцгой содон байдаг. Энэ нь шигүү суурьшилтай барилгажсан талбайн зүүн хойд захад, тэгэхдээ хойгуураа цөөн хэдэн тусгай барилгатай хаяа нийлсэн, харин зүүн талаараа ямар ч байгууламж байхгүй ийм байршилтай юм. Уйгурын уран барилга дахь дорно зүгийг дээдэлдэг уламжлалаар бодож үзвэл дүүргийн ганц хаалга нь зүүн талдаа байх нь энгийн хэрэг мэт атлаа түүнээс зүүн тийшээ цулгүй хоосон газар байх нь гайхмаар. Өргөн чөлөө гудамжнуудын чиг шугамтай уялдуулдаг барилгын зохион байгуулалт талаас авч үзвэл Ордон, эсвэл Сүмийн дүүргийн хаалганы энэ байрлал оновчгүй мэт. Байрлалын тухай асуудалд бүрэн дүүрэн хариулт өгөх аргагүй. Гэвч нэг талаас хэрэмт байгууламжаас зүүнших газар Орхон голын голдрилтой ойрхон, нэлээд чийглэг тул барилга барихад тохиромж муутай, нөгөө талаас хойшоо хаяа тулж буй газар нь ч бас намагтай байдаг. Ийм учраас хотын бусад бүхий л барилга байгууламжууд баруун тийшээ болон урагшаагаа илүүтэй тархан байрласан байдалтай. Тайлбар хийхийг оролдсон өөр нэгэн зүйл бол хотын янз бүрийн дүүргүүд ижил цаг үеийнх мөн үү гэдэг асуудал юм. Жишээлбэл, Ордон, эсвэл Сүмийн дүүрэг хэмээж буй тэр газар эртний Түрэгийн үеэс соёл, засаг захиргааны төв байснаас шалтгаалан уйгурууд эхний ээлжинд өөрсдийн цэргийн гол хүчийг байршуулах хуаран болгосон байж болно. Анхандаа гав ганцаар оршиж байсан дүүрэг 744/745 онд Уйгурын хаант улс байгуулагдсантай холбогдон худалдаа, алба гувчуурын харилцаагаар дамжин ахин дэвжсээр эцэстээ суурьшлын томоохон төв – Ордубалык хот болж өргөжсөн бололтой.

Тодорхой зааглан ялгаж болохуйц өөр нэгэн барилга байгууламжийн бүтэц Ордон, эсвэл Сүмийн дүүрэг гэдгээс урагш хэдхэн зуун метрийн зайтай оршино. Энэ бол гурван хэлээрх бичээстэй хөшөөний хагархай байгаа давхар хэрмээр хүрээлэгдсэн цогцол-

бор болно. НВ 2 дүүргээс холгүй орших, гол ба туслах барилгуудтай байсан нь тодорхой мэдэгдэх цогцолборыг гэрэлт хөшөөтэй холбоотой гэдэг үүднээс Монгол-Германы Орхон шинжилгээний анги сонирхон судалсан юм. Түүнийг НВ 1 гэж нэрлэсэн.

Ордон, эсвэл Сүмийн дүүргээс урагшаа олон барилга байсан нь хоорондоо гоц гойд ялгарах зүйлгүй бөгөөд бас томоохон байр сууцнууд нь гудам, далангаар зааглагдсангүй. Харин гол их гудамжны хойд үзүүрт 1000 м × 1000 м орчим хэмжээтэй тусгай хэрмээр хүрээлүүлсэн хороолол буй нь содон харагддаг. Энэ хорооллын хэрэм зүүн талдаа төв өргөн чөлөө рүү харсан нэг хаалгатай бөгөөд дотор ханын дагуу бараг 500 м үргэлжилсэн урт зурвастай. Хар балгасын энэхүү дүүргийг судалгааны ажлын тэмдэглэлд НВ 3 гэж нэрлэв.

Хар балгасын хот төлөвлөлтийг задлан шинжлэхэд, хотыг хамгаалах их хэрэм байгаагүй нь нэлээд анхаарал татдаг. Хотыг сахихад, магадгүй Орхоны сав газрын дунд биед нэвтрэн орох гол замуудыг сэргийлэх харуул байрлуулахад л хангалттай байжээ. Нэг талаас, хот баруун зүгтээ Хангайн нурууны салбар уулс, зүүн зүгт Орхон голын хооронд оршиж, хойгуураа намагтай газар зэрэг байгалийн бартаа саадаар хамгаалагдсан тул ихээхэн хүч хөдөлмөр зарцуулан хэрмээр хүрээлүүлэх нь илүүц байсан бололтой. Нөгөө талаас, нүүдэлчдийн хотууд ба суурьшлын төвүүд нь дундад зууны Европын ч юм уу, эсвэл Тангийн үеийн хятадын хот хэмээх ухагдахуунаас өөр байсантай холбоотой буй за.

Юуны өмнө хотын байгууламжийг авч үзвэл ижил үеийн Хятадын Тан гүрний хотуудынхаас өөрөөр төлөвлөгдсөн байна. Хятадын эзэнт гүрний уран барилгад тэгш хэмт чанар хийгээд барилгуудын хоорондох эрэмбэ дарааллын найрал зохицлыг тэнхлэгээр нь тохируулж илэрхийлэх загварыг чанд баримталдаг. Гэтэл Хар балгаст энэ зарчмыг төдийлэн анхаарсангүй. Ордон хот нь төв хоймортоо байрлаж, гол тэнхлэгийн дагуу өргөн чөлөө гудмаар шууд төв хаалга руу явж очдог бол Хар балгасын хувьд харин бүр эсрэгээр, төв гудамжаар яваад Ордон, эсвэл сүмийн дүүргийг тойрон явж байж хаалганд хүрэх зохион байгуулалттай байжээ. Хар балгасын өмнө хэсгийн хотын бүтэц нь өнөөгийн Таджикистан дахь 8 дугаар зууны эхэн хагасын үеийн Согдын хот болох хуучин Пенджикент мэтийн дорнод Иранаас үүсэлтэй хотожсон төвүүдийг илүү санагдуулдаг. Тэнд Хар балгасынхтай тун адилхан, хэвшмэл байсан зүйлүүд гэвэл, төвөөсөө хол байрласан гол гудамж болон түүний дагуу шигүү байрласан барилга сууцнууд болох юм.

Малтлагын үр дүн

НВ 1 – Манихейн шашны зан үйлийн цогцолбор

Энэхүү байгууламжийн гол барилга нь нийт хэрмийн цогцолборын хамт, түүний төв дунд орших гурван хэлээрх бичээстэй уялдаа холбоо бүхий болно. Түүний утга санааг төв тэнхлэг дээрх байрлал хийгээд уран барилгын хэв маяг, шавар дэлдэж хийсэн тавцан суурийн бүтэц хэсгүүд илэрхийлж байдаг. Барилга нь барилга байгууламжийн хоёр үе шат бүхий болох нь тодорхой болсон. Эхний үе шатанд гишгүүр, өгсүүр тавцангуудаар өргөтгөн барьсан шавар довжоог байгуулжээ. Тал нутгийн хөрсөн дээр үндсэн суурь довжоог шавар дагтаршуулан дэлдэх аргаар үйлдэж зарим газар түүхий тоосго хэрэглэжээ. Дээд талын тавцангийн дээр ямар нэг юм барьсангүй. Зөвхөн хойд болон баруун талд, бас өмнө талд хана байсан бололтой зүйлийн үлдэгдэл гарсны дотор талыг шавардаж будсан байлаа. Барилгын энэхүү эхний үе шатанд довжоо суурийг байгуулах гэж дэлдсэн гишгүүр, өгсүүр тавцангууд хамаарч байна.

Довжоон дээр зүүн болон баруун талаас нь, өгсүүр тавцангийн дээр байгуулсан шатаар гарч байсан бололтой. Хойд ба урд өгсүүр тавцангууд барилгын эхний үе шатанд хамаарах эсэх нь баталгаатай бус. Эдгээрийг нэвт гарч болох хаалга орцны зүйлтэй холбоотой гэж үзсэн бөгөөд барилгын урдах талбайгаас тусгаарлагдсан голын тавцангийн зүүн хэсгийн хойд урд жигүүрийг өргөтгөх маягаар барьж байгуулжээ. Довжоон дээрх зүүн талын хоёр өгсүүр тавцанд хэвтээ гишгүүрүүд (В 1015) байгаа нь барилгын эхний үе шатанд хамаарна. Босго мод, түүний хоёр талаас олдсон шонгийн нүх зэрэг олдворуудаас үндэслэж энд хаалга үүд байсан гэж таамагласан. Цогцолборын төв тэнхлэгийн баруун хэсэгт байгаа ар тал руу хандсан дотоод хүрээгээр дараачийн барилга руу хүрдэг байжээ. Энд бас тавцангийн дээгүүр тавьсан шатаар явж хүрдэг байсан бололтой. Өөрөөр хэлбэл, эдгээр барилга хоорондоо холбоотой байжээ. Дотоод хүрээг зүүн баруун талаас нь хашсан хана байсан нь тавцан суурийн гадагш хандсан өмнөд хүрээ хэсгээр мэдэгдсэн. Байрнаасаа хөдөлсөн хоёр боржин хавтан, анхны байрандаа буй ганц баганын суурь илэрсэн. Төв тавцан суурийн баруун хойд буланд бусад сууриуд байсан нь мэдэгдэх бөгөөд үүгээр барилгын бусад хэсгүүд ямар байсныг багцаалж болох юм.

Барилга байгууламжийн хоёр дахь үе шатанд төв гол суурийн гадаргууг зүүн тийш нь өргөтгөн, өмнө талын довжооны төвшинг (В 1015) тавцангийн хамгийн дээд төвшинд хүртэл өндөрлөжээ. Энэ хэсэг өөд эгц өгсүүр тавцангаар явж хүрнэ. Довжоо суурийг чимэглэн зассан учир шалтгаан тодорхой бус. Төв барилгыг

түүнийг хүрээлэн буй давхар хэрэмт цогцолборын хамт барьсан нь илэрхий болохыг батлах зүйлүүд барилгын зарим хийц бүтцээс харагдана. НВ 1 цогцолбор нь бүхэлдээ гаднах хэрэмтэйгээ нэг тэнхлэг дээр зэрэгцээ шугамаар баригдсан нь энэхүү байгууламжийг бүхэлд нь нэг цаг үед барьж байгуулсныг гэрчилж байдаг. Гэвч төв барилга ямар үүрэг зориулалттай байсан гэдэг нь тодорхойгүй. Гурван хэлээрх бичээс хотыг байгуулснаас хойш нэлээд хугацааны дараа буй болсон бөгөөд давхар хэрэмт байгууламжийг барих үед түүнийг төв дунд нь залснаас хойш байрнаасаа хөдлөөгүй мэт байна. Түрэг судлалд бичээсийг бүтээсэн он цагийг 815, 821, 834 он хэмээн маргалдсаар байгаа нь цөм Хар балгасын оршин тогтнож байсан цаг үеийн сүүл хагаст хамаарч байна. Бичээсийн агуулга нь 762 онд манихейн шашныг хүлээн авсан тухай өгүүлдэг. Эндээс үзэхэд давхар хэрэмт цогцолборын төвд байршуулахаар сонгож авсан нь манихейн шашинтай бас холбоотой бөгөөд уг байгууламж нь шашны зан үйлийн үүрэгтэй байсан болов уу гэсэн таамаглалыг төрүүлдэг. Барилгын ажлын хоёр дахь үе шат нь гэрэлт хөшөөг цогцлон босгож цогцолборыг манихейн шүтээний газар болгож зохион байгуулсантай холбоотой болов уу.

Туслах барилгууд: Одоогоор хоёр өрөө малтаж гаргасны нэг нь барилгын баруун хойд буланд, нөгөө нь түүний зүүн хананд байсан болно. Хоёулаа дагтаршуулсан шавар шалтай бөгөөд ханыг нь дотор талаас нь шаварджээ. Эдгээр өрөөний зай талбайгаас шалтгалалан зарим хэсгийг малтаагүй тул илүү тодорхойлох боломжгүй. Хоёр өрөөний шалны төвшин 35–40 см орчим зөрүүтэй. Ханын тухайд доод хэсгийг нь шавар дагтаршуулан дэлдэх аргаар хийсэн. Нурж унасан түүхий тоосгоны үлдэгдлүүд байгаа нь ханын дээд талыг тоосгоор өрж хийснийг гэрчилнэ. Хадгалагдан үлдсэн ханын бүх үлдэгдлүүдийн дотогш хандсан талыг шаланд нь тулгал цайвар өнгийн шохойн зуурмагаар шавсан байлаа. Хоёр өрөөний дэвсгэр зургийг одоогоор бүрэн гаргах боломжгүй. Барилгын цогцолбортойгоо ижил зүүн талдаа хаалгатай байсан эсэх хийгээд төв барилга руу хүрэх орц шат байсан нь нотлогдоогүй.

Зүүн ханыг нь судалгаанд хамруулсан өрөөний өмнө залгагдсан барилгын өргөтгөлд урд талдаа хаалга бүхий зүүнээс баруунш 1,20 м өргөн, дотор талыг нь шавардсан хөмөг буй. Үүнийг LiDAR-Scan зурагт ажиглаж үзэхэд, хөмөг байгаа газар нь төв барилгын доторхи хонхор маягтай, тухайн газар урд үзүүр нь байрлаж буй өрөө тасалгаа мэт үзэгдэнэ (В 0037). Өмнө залгагдсан хэсэгт ийм хонхор байхгүйн учир нь шавар дэлдэж хийсэн хатуу суурьтайгаас болсон бололтой. Баруун хойд барилгын цогцолбор ерөөс зүүн талдаа хаалгатай байсан эсэх нь одоогоор нотлогдоогүй. Тавцангийн нь чиглэлээс харахад илүүтэй урагшаа хандсан гэмээр байрлалтай байдаг. Үүнийг хо-

жмын малтлага судалгаагаар тодруулах буй за. Төв барилга, баруун хойд талын туслах барилгын хооронд том хонхор буйг, цогцолборын дотор талд байсан задгай хүрээлэн гэж төсөөлж болно. Төв барилгын хойно байгаа өгсүүр тавцангаар зааглагдсан тус барилгын чуулган доторхи туслах барилга урагшаа чиглэсэн байрлалтай.

Хоёр өрөөг малтах явцад бүхэлдээ барилгын дээд хэсгийн нуранги, ханын үлдэгдэл, дээврийн хэсгүүд олдсон.

Барилгын он цагийг керамик олдвороор тогтоож болно. В 0012 дугаартай олдворын цогц байдал нь В 0011 дугаартай шалан дээр тогтсон нуранги бөгөөд тэндээс Уйгурын буюу эртний Түрэгийн хэв шинжтэй хээ чимэглэл бүхий ваарны хагархай хэсгүүд олдсон. Уйгурын цаг үеийнх хэмээх он цаг C_{14} -ийн шинжилгээгээр батлагдсан болно. Эндээс олдсон нэгэн булшны олдвор барилгын хожуу цаг үеийн үйл явцыг харуулж байна. Баруун хойд өрөөний баруун талд, барилгын шаваастай хана болон шалны хэсгийг хажуу тийш нь хөндийлж ухаад оршуулга үйлдсэн нь эртний Монголын үеийн хөмөгт булш бололтой. Оршуулганд дагалдуулсан эд өлөг ба хүүрийн толгойг чанх хойд зүг чиглүүлэн тавьсан байрлал зэрэг нь Уйгурын үеийнхээс өөр юм. Хүний ясны олдворын судалгааны дүнг хүлээж байгаа болно.

Хэрмийн малтлага: НВ 1 давхар хэрэмт цогцолборын хойд талын гадуур хэрмэнд зүсэлт хийж үзэхэд малтлага хийсэн тэр газраас түүнийг барьсан бүтэц, зохион байгуулалтын талаар тоймтой мэдээлэл авах эх хэрэглэгдэхүүн илэрсэнгүй. Гадуур хэрэм нь хамгаалалтын гэхээс илүүтэй уг цогцолборыг тусгай дүүрэг гэдгийг илэрхийлэх төдий зүйл байжээ. Уг хэрэм 3 м өргөн, дор хаяж 1,20 м өндөр байсан аж. Цогцолборын доторхи, төв барилга мэтийн зарим томоохон барилга байгууламж хэрмийн гадна талаас харагддаг байсан гэж бодмоор. Дотуур талын хэсгээс нь нурж унасан дээврийн ваарны хагархай нэлээд олдсоноор үзэхэд зарим хэсгийг нь дээвэрлэж байсан бололтой.

НВ 2 – Ордон /Сүмийн дүүрэг

Ордон, эсвэл Сүмийн хэмээгдэх дүүргийн дотор тэнхлэг чиглэлийнхээ хувьд онцгой агуулга бүхий, барилгын нэгэн чуулбарт хамаарагдах хоёр том овгор байдаг. Тиймээс энэ хоёр овгорт хийсэн малтлагуудын үр дүнг харилцан уялдаа бүхий хэмээн хамтад нь дүгнэсэн болно.

Баруун талын овгор нь шавар тавцан дээр байгуулсан нэгэн барилгын турь бөгөөд хэрмийн хаалгаар орж зүүн талаас нь бараалахад зүүн талд буй овгор буюу баруун тийшээ дотуур хүрээгээр холбогдсон барилгынхаа цаад талд байрлалтай харагдах ажээ. Уг ба-

рилга нүүрэн талдаа 5 м орчим зурвас талбай бүхий задгай асартай байсан бөгөөд үүдний асрын дээврийг нэгэн эгнээнд байрлуулсан 9 багана тулж байжээ. Модон баганууд хадгалагдаж үлдээгүй боловч боржин чулуу засаж хийсэн чулуун сууриуд нь хэвээр хоцорчээ. Чулуун сууриудыг Тан улсын маягтай хээ угалзаар чимэглэсэн нь илэрхий боловч зохион байгуулалтын хувьд хятадын уран барилгад баримталдаг дүрэм журмаас баахан гажууд, сондгой тоотой байх аж. Ийнхүү тэгш бус тоотой багана (zhu) байгуулснаар тэдгээрийн хоорондох зай буюу жян (jian) нь тэгш болсон барилга аж. Танхимын хүрээ нь хөх өнгийн шавар шалтай бөгөөд урд хэсэгтээ хоорондоо залгагдсан дөрвөлжин хэлбэрийн модон жаазнуудаар зааглагдсан. Дотоод орон зайг шавар дагтаршуулан дэлдэж хийсэн ханын үлдэгдлүүд хувааж байна. Энэхүү шавар ханын гол нь хөндий бөгөөд шатаж хатуурсан үзэгдэх нь үүн дотор модон хийц хэсгүүд байсныг харуулна. Эдгээр нь барилгын дээврийг тулж байсан, эсвэл ямар нэгэн хөшөө баримал мэт юмны тулгуур суурь байсан байж болно. Үүнтэй харьцуулж болох зохион байгуулалт Кыргызстаны Ак-Бешим дахь 7 дугаар зууны үеийн бурханы шашны сүмийн баруун хэсгээс олдсон байдаг. Тэр сүмийн модон багануудыг барилгын ханын дотор талд хийсэн бөгөөд бас тэнд бурхадын дүрс залах хөндий гуу байрлуулж тэдгээрийн төв дунд тахилын саваа гэгч зүйлийг босгож тавьдаг байжээ. Энэхүү нийтлэг зүйлс нь манихейн шашны хэв шинжтэй барилгыг ойлгоход чухал юм. Учир нь манихейн шашинд бусад шашнаас, түүний дотор бурханы хөрөг зургийн урлал болон уран барилгын талаар хүлээн авсан зүйлс бишгүй байдаг. Ялангуяа Хар балгасын төв дэх хэлэлцэн буй барилгын баруун талд буй суваргатай холбож ярихад, бурханы шашинд шүтээний үүрэгтэй байдгийн адил манихейн чуулганд ч бас иймэрхүү утга агуулгатай байжээ.

Үүдний танхим руу орох хэсэг хэмээн төсөөлж буй талбайн урт 16 м, өргөн 29 м орчим бөгөөд дөрвөлжин хэлбэртэй, шатаасан тоосгон хавтангуудаар хүрээлэн шаллаж байсны үлдэгдэл хойд, баруун талаас нь олдсон. Хойд хэсэгт уг шалыг 3 м урт шавар зурвас огтолсон нь ялгарч харагдана. Малтлагаас суварганы зүг чиглэсэн баруун талын хаалга байсныг гэрчлэх зүйл гараагүй. Малтан судалсан бусад хэсгүүдээс ер нь уг барилга ямаршуу дүр төрхтэй байсныг харуулах хангалттай баримт хэрэглэгдэхүүн олдоогүй.

Шавар дэлдэж хийсэн ба түүхий тоосгоор өрсөн ханын зэрэгцээ мод шавар хосолсон бүтцийг түлхүү ашиглаж байжээ. Эднийг барьж байгуулсан үндсэн хийц нь ямагт дүнзэн гуалин хэвтүүлэн суурь тавьж дээрээс нь шавар нялж хийсэн бүтэцтэй байдаг. Юу байхаас нь шалтгаалан ийм тулгуурын заримыг хана болгон өргөтгөсөн байна. Чингэхдээ хөндлөвч дүнзэнд арай жижиг бэхэлгээ моднуудыг босоо байдлаар холбож гаднаас нь шавардана. Тийм бэхэлгээ модны зарим

нь шавар дэлдэж хийсэн ханын хөлд орсон байна. Олонтаа илэрч гардаг дээврийн нүүр ваар болон баганын чулуун суурийн хээ чимэглэл, тэрчлэн барилгын довжооны өмнөд хэсгийг чимэглэж байсан боржин чулуун лууны толгой зэрэгт Хятадын Тан гүрний урлагийн нөлөө үзтэл илэрхий байна. Хятадын уран барилгын баганын дүрэм гэх мэтийг үл тоомсорлосон байх боловч зарим тодорхой зүйлсийн тухайд бол энэ мэт нөлөө ба үлгэр загварыг цааргалах юмгүй авч хэрэглэдэг байжээ. Барилгын хамгийн чухал хэсэг байх ёстой төв гол хэсэг нь хуучин малтлагуудаар ихээхэн эвдэгджээ. Тавцан суурийн дээд талын үе давхаргын дороос шавар ухаж суулгасан модон жаазны бүтэц илэрсэн. Энэ дүнзэн гуалингаас дээж авч C_{14} -ийн он цаг тогтоох шинжилгээ хийлгэхэд Хар балгасыг байгуулахаас 100 жилийн өмнөх хөгшин настай мод болох нь тогтоогдсон. Гэвч шинжилгээний үр дүнгүүдийг ангилж цэгцлэхэд цөөхөн дээж авсан гэдгийг харгалзан үзэх ёстой. Тэрчлэн Уйгурын хаант улс (744) байгуулагдахаас өмнөх цаг үеийн ямар нэгэн барилга байгууламж байсныг нурааж барилгын материалыг нь дахин ашигласан байж болно. Энэ тохиолдолд баруун талын овгор нь 744/745 онд Уйгурын эзэнт гүрнийг зарлан тунхаглахаас өмнөх цаг үеийнх буюу тус хотын одоогоор мэдэгдэж буй хамгийн эртний хэсэг болж тарах юм. Хэрэв тийм бол ерөөс хэрэм бэхлэлт байгуулаагүй юмуу эсвэл маш бага байх цагийн эртний Уйгурын ördü энд байжээ гэж төсөөлж болно. Энэхүү дэвсгэр дээр авч үзвэл есөн баганы суурь нь 9 овгийн уйгуруудыг нэгтгэсэн улс хэмээх утгатай утга төгөлдөр тоон бэлгэдэл болж байна. Хуучин ямар нэгэн суурин, эсвэл тахилын газар байсан тэр газрыг хуран чуулах талбараа болгож, Уйгурын овог аймгуудын нэгдмэл байдлыг гаднах өнгө төрхөөрөө илэрхийлж байсан юм болов уу. Аль ч тохиолдолд өндөр хэрмээр хүрээлүүлсэн дүүрэг бол Уйгурын хаант улсын засаг захиргаа, шашны төв байсан нь гарцаагүй юм.

Тооны бэлгэдлийн зэрэгцээ янз бүрийн олдворуудын чимэглэлээс харагдаж буй геометрийн нэгэн дүрс чухал ач холбогдолтой байжээ. Тухайлбал, тоосгон хавтан дээр сийлж гаргасан ийм дүрстэй олдвор гурав гарсан нь жиргээ хэмээх хөлөгт тоглоомын өрөг байв. Тийм ч учраас эдгээр олдвор нь барилгыг тайлбарлахад сонирхолтой хэрэглэгдэхүүн болно. Олдвор дээрх өнцөг булангуудыг нь шугамаар холбосон тэгш дөрвөлжин гурван нүдний дүрс өрнөдөд Twelwe Men's Morris гэж нэрлэдэг, арван хоёр хасаагаар тоглодог нэгэн зүйлийн хөлөгт тоглоомынхтой ижилхэн юм. Манихейн ахуй нөхцлөөс үүсч гарсан гэж үздэг энэхүү тоглоом Загалмайтны аян дайны үед Темплер хэмээх шашны бүлгэмээр дамжин Европт нэвтэрсэн аж. Арван хоёрын тоо нь уйгуруудын хувьд нөгөө хачирхалтай 9 баганы суурийн нэгэн адил эрхэм тоо байсан гэдгийг эргэцүүлэн бодвол энэ нь Буддын шашных

гэхээсээ илүүтэй Манихейн ёстой уялдаа холбоотой байх учиртай.

Зүүн талын овгорт байсан барилгын хэмжээ ба архитектурыг сэргээн төсөөлөх хэмжээнд хүрсэн малтлага хийгдээгүй. Энд бас л тусгайлан дагтаршуулсан тавцан засаж дээд талыг нь шавардаж шалласан байжээ. Зэрэгцээ байрлалтай хөндлөвч моднуудын ул мөр энд тэнд харагдаж буй нь тусгай хэсэг буюу өрөө тасалгаа байсныг нотлох баримт мөн.

Барилгын овгорын зүүн хэсэгт 7 м × 8 м хэмжээтэй гадаргууг нь дахин ашигласан бололтой барилгын материалын хаягдал дэвсэж шалласан довжоо буй. Он цаг тодорхой бус. Шалны төвшинд хана, шон юмуу баганын суурь гэх мэт ямар нэгэн барилгын хийц зохион байгуулалт мэдэгдээгүй. Тэрчлэн барилгын халга үүд хаана байсан нь мэдэгдээгүй. Хожим энд малтлага судалгаа хийх шаардлагатай.

Контекст

Төв Азийн дорнод хэсгийн нүүдэлчин аймгуудын хот суурины археологийн судалгаа нь дөнгөж эхлэлийн шатандаа байгаа билээ. 19 дүгээр зууны сүүлчээр томилон ажиллуулсан шинжилгээний ангиудын судалгаагаар илрүүлэн олсон хэрэм, байгууламжуудыг судлах ажил өнгөрсөн зууны дунд үеэс эрчимжиж эхэлжээ. Монголын хувьд монгол археологич Пэрлээ хот суурины археологийн дурсгалуудыг системчилсэн байна. Тувагийн нутагт Кызласов Енисей болон Хемчик голын сав дагуух хэрэм бэхлэлтүүдийг нарийвчлан судалсан. Өмнөд Сибир, Өвөр Байгалын хожуу нүүдэлчдийн соёлуудын хот суурины түүхийн тухай сүүлийн үеийн судалгааны үр дүнг тусгасан бүтээлийг Данилов 2004 онд нийтлүүлжээ. Тун цөөхөн тохиолдолд археологийн малтлага судалгаа хийсэн бөгөөд олонхи суурингийн он цагийг түүвэр олдвор, эсвэл чиглэл, ойр буй оршуулгын газар гэх мэт бүтэц зохион байгуулалтын онцлогоор тодорхойлж байлаа.

Хүннүгээс Уйгур хүртэлх хожуу нүүдэлчдийн эрин үеийн дурдан буй хот суурингуудыг тууштай үргэлжилсэн суурин судалгаа буюу археологийн малтлага хийлгүйгээр хотын археологийн үүднээс ангилж цэгцлэхэд бэрхшээл тулгарна. Ялангуяа Уйгурын цаг үеийнх хэмээн үзэж буй хэрэмт байгууламжуудыг маш цөөн тохиолдолд сорилтын журмаар бага сага малтсан байна. Иймээс Уйгурын хот суурины тухай итгэл үнэмшилтэй дүр зураг гарган үзүүлэх боломж алга.

Хожуу нүүдэлчдэд харьяалагдах суурин газар, хэрэм бэхлэлтүүд анх Хүннүгийн үеэс буй болжээ. Данилов Иволгын зэрэг хүчирхэг бэхлэлттэй суурингуудыг хоргодох зориулалттай байсан гэжээ. Гэсэн хэдий ч иймэрхүү суурингуудын зарим нь түрүү үеийн буюу

эртний хотын шинж чанарыг агуулж байсан бөгөөд тэнд оршин суугчид нь анх удаа нэгдэж нийлэн газар тариалан, төмөрлөг боловсруулах ажлыг хамтын хүчээр эрхлэх боломжтой болсон байна. Энэ нь морьтон нүүдэлчин аймгуудын дундах цэвэр нүүдэллэн малжих аж ахуй нь онцгой зүйл хэмээх зүйд нийцсэн таамаглалыг дэвшүүлэн гаргахад хүргэсэн юм. Энэ тухай Миняев цохон тэмдэглэхдээ, Хүннүгийн үед нүүдэлчин ахуйтай Төв Ази нь анх удаа хотжих шатанд алхан орсон бөгөөд үүний шалтгаан нь цэрэг дайны стратегийн гэхээс илүүтэй эдийн засгийн үндэстэй байсан гэж үзжээ.

Хожуу нүүдэлчдийн аймгийн холбоодын хот суурины түүхийн судалгааны чухал асуудал бол зөвхөн уран барилгын хийц, хэлбэр хэмжээ төдийгүй тэдгээрийн байршил, залгамж чанарын тухай асуудал байдаг. Жожуаньчууд хоёр хэрмээр хамгаалуулсан нийслэлтэй байсан гэх зэргээр хятад сурвалжид мэдээлж буй ч гэсэн Хүннүгийн дараа Төв Азид ноёрхож байсан Сяньби, Жожуань зэрэг улсуудын хот сууринг олж тогтоогоогүй байна. Бусад талаар эдгээр аймгийн холбоод нь өөрийн оршин ахуй байдлаараа хөрш орнууддаа ялгарч харагддаггүй байжээ. Эртний Түрэгийн хаант улс тогтноод харь орнуудыг боолчлон мөлжих Хүннүгийн бодлогыг үргэлжлүүлэв. Тэд Хятадыг шахамдуулан алба татвар авч тив дамнасан замаар Византи ба Арабын орнууд хүртэл худалдаа арилжаа хийж байлаа. Иймээс Пэрлээ эртний Түрэгийн хот суурин байх ёстой гэж таамаглаж байсан. Гэвч өнөө болтол хүсэн хүлээсэн баримт нотолгоо олдохгүй л байна.

Бэхлэгдсэн суурин газрууд олдоогүй байгаа ч гэсэн бичгийн сурвалжууд, гэрэлт хөшөөний бичээс болон Хөшөө Цайдам дахь тахилын онгоны дурсгал зэргээс Орхоны хөндий дэх Өтүкэн газрын эрхэм чухал ач холбогдолтой нь илэрхий байдаг. Түрэгийн хоёрдугаар хаант улсыг залгамжилсан Уйгурын эзэнт гүрэн хожуу нүүдэлчдийн аймгийн өмнөх холбоотой харьцуулахад, өргөжин тэлсэн нийслэл хотыг үндэслэн байгуулснаараа онцгойрч байдаг. Өтүкэн газар хот байгуулах газраа сонгож авсан нь эртний түрэгийн уламжлал гэдгийг Хар балгасаас холгүй орших Хөшөө Цайдамд буй тахилын цогцолбор гэрчлэн харуулна. Нийслэл хотын орчин тойронд олон жижиг хэрэм байдаг нь Уйгурын үед тэдний цэрэг стратеги, засаг захиргааны ач холбогдолтой суурингууд байсантай холбоотой гэж үздэг.

Хожуу нүүдэлчдийн үеүдийн олон янзын хэрэмт байгууламжуудыг хооронд нь харьцуулж үзэх хангалттай жишээ хомс хэвээр байсаар. Гэсэн ч зарим дүгнэлт хийж болох юм. Барилга барих аргын тухайд, шинжлэх ухааны малтлагаас мэдэгдэж байгаагаар, бүх үеийн туршид Төв Азийн түүхий эдийн эх булаг, техникийн мэдлэгт ойрхон шавар дэлдэх ба түүхий тоосго хэрэглэх явдал түгээмэл байжээ. Харин уйгуруудын хувьд Хар балгас, Байбалык мэтийн томоохон хотожсон

төвүүдийг байгуулж чадсанаараа онцгой болно. Тэд зөвхөн улирлын чанартай сэлгэн суух харьцангуй бага хэмжээтэй хэрэм төдийхөн бус харин томоохон талбайг эзэлсэн мянга мянган хүн амьдран суух төвүүдийг барьж байгуулжээ. Энэхүү хөгжил дэвшилд олон талаар үлэмж хувь нэмэр оруулснаараа Уйгурын хаант улс хожуу нүүдэлчдийн урьд өмнөх аймгийн холбоодоос ялгарна. Уйгурын хаант улс нь хятадын Тан улстай онцгой харилцаатай байсан нь нэг хүчин зүйл байжээ. Хятадын хааны ордонд босогчдоо дарахад нь өөрийн хүчирхэг цэргээ илгээж тусалсныхаа хариуд уйгурууд хэмжээлшгүй их »шан харамж« хүргэж, эзэлсэн хот суурингуудыг хоосортол дээрэмдэж байв. Тэрчлэн »худалдааны хэлэлцээр« хэмээх нэрээр зүсээ хувиргасан алба татвараар уйгурууд хятадтай харилцах харилцаанаасаа тэдэнтэй харьцуулах аргагүй ашиг хонжоо олж байжээ. Уйгурын хаанд бэлэг сэлт, алба татвараар эд таваар, түүний дотор тансаг хэрэглээний зүйлс ирж байв. Бараа таваарын зарим хэсгийг Торгоны замаар дамжуулан Иран, Византи, Арабын орнуудад худалдаж байсан бөгөөд тэдгээрийг хадгалах,

худалдах газар шаардлагатай байв. Тив дамнасан олон улсын худалдааны сүлжээг хянах хааны зөвлөхийн үүрэг гүйцэтгэж, Уйгурын ноёрхогчдын ордон дахь нөлөө бүхий хүмүүс болсон согдууд тэрхүү худалдаа арилжаанд нэн идэвхтэй оролцож байлаа. Тэднээр дамжуулан уйгурууд манихейн шашинтай танилцаж улмаар төрийн шашнаа болгож авсан нь цаашид соёлын нь хөгжилд хувьсал өөрчлөлтийг авчирсан юм. Хожуу нүүдэлчдийн хуучин аймгийн холбоодтой харьцуулахад, худалдаа арилжааг үлэмж хэмжээгээр хөгжүүлэн манихейн шашныг хүлээн авсан нь магадгүй хотжин суурьших шаардлагыг буй болгосон юм болов уу.

Хожуу нүүдэлчдийн хэрэмт байгууламжууд ба хот суурины бүтэц, зохион байгуулалтыг археологийн үүднээс тайлбарлахад хүндрэл бэрхшээл гарсаар байгааг дурдахгүй орхиж боломгүй. Гэвч Хар балгасын судалгаа зэрэг алхам урагшилсан хот суурины археологийн шинжилгээ сүүлийн жилүүдэд хийгдэх болж, үүний хамт Уйгурын нийслэлийг хотын археологийн үүднээс судлах ажил ч урагштай үргэлжилсээр байна.

